



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 05 өдөр

Дугаар А/05

Бсөнбулаг

Орон нутгийн нүүрс тээврийн
чиглэл тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Авто тээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.4 дэх заалт, 10 дугаар зүйлийн 10.2.5 дахь заалт, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5, 12.1.8 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсэг, Төгрөг сумын Хүрэн гол багийн иргэдийн Нийтийн хурлын тэмдэглэл, Төгрөг сумын Засаг даргын 01/202 дугаар албан хүсэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төгрөг сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй “Цэрдийн тал” ХХК-ийн МҮ020782 дугаартай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий 1 дүгээр багийн Бор энгэрийн уурхайгаас Өгөөмөрийн эхийн Алтай-Бургастай улсын хил чиглэлийн А1104 дугаартай авто замтай нийлэх хүртэлх 34.6 км орон нутгийн чанартай нүүрс тээврийн чиглэлийг баталсугай.

2.Батлагдсан нүүрс тээврийн чиглэлийн дагуу 34.6 км орон нутгийн чанартай авто замыг 2 жилийн дотор компани өөрийн хөрөнгөөр хатуу хучилттай болгож авто замын бэлэн байдлыг хангаж ажиглахыг “Цэрдийн тал” ХХК-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажиллахыг Төгрөг сумын Засаг дарга (Б.Чимэгбаяр)-д, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т тус тус даалгасугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ

